Гоо сайханд хэрэглэж байсан зарим эмийн түүхий эдийг Монгол эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний номуудаас тодруулахуй

Хөгжилт (Hugejiletu)[1], С.Доржбат[1], Я.Энхтөр[2], Ш.Болд[3,4]

[1]АШУҮИС, МАУОУС
[2]АШУҮИС, АУС
[3]"Ач"АУИС
[4]Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль
Цахим шуудан: boldshrv@gmail.com, Утас: 80687670

Түлхүүр үг:

Гоо зүйн шинжлэх ухаан
Эмийн ургамал
Гоо сайхан
Эртний анагаах ухааны ном
Монгол лам

Товч утга:

Үндэслэл: Сүүлийн 10 гаруй жилд Монгол Улсад гоо зүйн шинжлэх ухаан эрчимтэй хөгжих суурь тавигдсан ба үүнийг даган ургамлын гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол түүхий эд болох эмийн ургамлын судалгааг өргөн хүрээнд хийж байна. Монгол оронд 900 гаруй зүйлийн эмийн ургамал ургадаг. Гэхдээ эдгээр ургамлаас аль ургамал нь гоо сайханд хэрэглэдэг болохыг тогтоох нь судлаачдын анхаарлыг татаж байна. Үүнийг шийдвэрлэх гол аргаын нэг бол XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний судраас гоо сайханд хэрэглэдэг эмийн ургамлын түүвэр хийж тодорхойлох асуудал юм. **Зорилго:** XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний судраас гоо сайханд хэрэглэдэг эмийн ургамлын түүвэр хийж тайлбарлах. **Арга, аргачлал:** Бид энэхүү судалгааг эх бичиг, сурвалж бичгийн судлалын аргыг ашиглан судлаач М.Отгонбаяр (1995) нарын тодорхой нэг уламжлалын түүхийн жишээн дээр тулгуурлан мэдлэгийн трансформацын зүй тогтлыг илэрхийлэх арга зүйн зарчмуудыг баримтлан уламжлал шинэчлэлийн асуудалд улирал дэвших диалектик зүйн тогтнолын үүднээс хандахдаа В.Ф.Гегель (1837), Н.И.Конрид (1966), Л.Н.Гумилев (1989), Н.Хавх (1995) нарын үзэл баримтлалын ерөнхий чиг зарчмыг тус тус баримталж ажигласан болно. **Үр дүн:** Бид судалгаандаа эхлээд XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний 40 номыг олж цуглуулан ашигласан. Цуглуулсан ном болгоноосоо гоо сайхантай холбоотой, арьсны янз бүрийн өвчнийг эмчлэх эмийн ургамал, нийлмэл найрлагыг тогтоосон. **Дүгнэлт:** XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний 7 судраас гоо сайханд хэрэглэдэг идээ ундаа, амьтан ургамлын гаралтай эмийн түүхий эдийн түүвэр хийж тайлбарлав. Сүүлийн 10 гаруй жилд Монгол Улсад гоо сайхны шинжлэх ухаан эрчимтэй хөгжих суурь тавигдсан. Үүнийг дагаад ургамлын гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол түүхий эд болох эмийн ургамлыг олж тогтоох, судалгаа хийх шаардлага тавигдаж байна. Үүний гол нөөц, нотолгоонд суурилсан уламжлалт мэдлэгийг нээн гаргах гол боломжийн нэг нь анагаах ухааны эртний номуудыг судлах асуудал юм.

Үндэслэл: Судлаач, түүхчдийн тэмдэглэснээр буддын шашин нь Монголд гурван удаа дэлгэрсэн бөгөөд Хүннүгийн үеийн дэлгэрэлтийг анхдугаар, Их Монгол, Юань улсын үеийг дунд, 1578 оноос хойших үеийг хожуу үе хэмээн үздэг. Хожуу үеийн дэлгэрэлтийн эхлэлийг 1578 оноос эхлэсэн гэж үздэг ба энэ үеэс Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны мэдлэгт үндэслэсэн Төвөдийн анагаах ухаан Буддын шашны

мэдлэгийн хамт Монголд дэлгэрсэн. Ялангуяа "Анагаах ухааны дөрвөн үндэс" зохиол төвөд хэлээр дэлгэрсэн нь Монгол эмч нар төвөд хэлийг өндөр түвшинд эзэмших шаардлагатай болсон байна. Үүнийг ч монгол эмч, эрдэмтэд сайн биелүүлж, төвөд хэлний сургалтын монгол арга, монгол онцлогтой төвөд хэлний утга зохиолын чиглэлийг бий болгосон байна[1].

Монгол Улсад "Анагаах ухааны дөрвөн үндэс" номыг гол сурах бичгээ болгосон анхны Эмчийн сургууль 1685 онд байгуулагдсан. Энэ үеэс хойш Буддын томоохон сүм хийдийн дэргэд Эмчийн сургууль олон арваараа нээгдэж Монгол эмч нар бэлтгэгдэж эхэлжээ. Эдгээр эмчийн сургуулиас 1685-1922 оны хооронд олон зуун алдартай Монгол эмч, эрдэмтэд төрөн гарсан байна. Эдгээрийн дотроос Намхайжамц (1559-1662), Лувсанданзанжанцан (1639-1704), Лувсанпэрэнлэй (1642-1715), Гомбожав (1680-1750), Ишбалжир (1704-1788), Лувсанчүлтэм (1740-1810), Агваанлувсандамбийжанцан (1770-1845), Жамбалчойжиданзанпэрэнлэй (1789-1838), Жамбалдорж (1792-1855), Лувсанчойнпил (XIX зуун), Жигмэдданзанжамц (XIX зуун), Ишданзанваанжил (1852-1906), Агваангэндэн (XIX зуун), Ёндон (XIX зуун), Дандар (1831-1920), Чойжамц (1860-1928) нар анагаах ухааны олон арван ном судрыг төвөд хэлээр зохиожээ[2].

Сүүлийн 10 гаруй жилд Монгол Улсад гоо зүйн (cosmetic science) шинжлэх ухаан эрчимтэй хөгжих суурь тавигдсан ба үүнийг дагаад ургамлын гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол түүхий эд болох эмийн ургамлын судалгааг өргөн хүрээнд хийж байна. Монгол оронд 900 гаруй зүйлийн эмийн ургамал ургадаг. Гэхдээ эдгээр ургамлаас аль ургамал нь гоо сайханд хэрэглэдэг болохыг тогтоох нь чухал болоод байна. Үүнийг шийдвэрлэх гол арга бол XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний судраас гоо сайханд хэрэглэдэг эмийн ургамлын түүвэр хийж тодорхойлох явдал юм.

Зорилго: XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний судраас гоо сайханд хэрэглэдэг эмийн ургамлын түүвэр хийж тайлбарлах.

Арга, аргачлал:

Судалгааны хэрэглэгдэхүүн: Дараах анагаах ухааны эртний номыг судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглав. Үүнд:

- Лувсанданзанжанцан (1639-1704)-гийн "Увдисын рашааны цацрал"
- Ишбалжирын "Дөрвөн рашаан", "Цагаан болор эрхи" (1752)
- Жамбал "Увдисын далай" (1829)
- Жамбалдорж "Үзэсгэлэнт нүдэн чимэг" (1851)
- Лувсанчойнпилийн "Нандин эрдэнийн шимийн хураангуй"
- Жигмэдданзанжамцын "Үзэгсдийн баясгалан" (1888)

Эдгээр Монгол зохиогчтой анагаах ухааны эртний судрууд нь бүгд Төвөд хэлээр бичигдсэн ба одоогоор судлаач Ш.Болдын хувийн номын санд хадгалагдаж байна.

Эх бичиг, сурвалж бичгийн судлалын арга: Бид ***с***удалгаанд ашигласан хэрэглэгдэхүүнээ ажлынхаа зорилгодоо нийцүүлэн цаг хугацааны хувьд хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн улмаар гол агуулга, шинэлэг санааг шүүн тунгааж судалгааг хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ судлаач М.Отгонбаяр (1995) нарын тодорхой нэг уламжлалын түүхийн жишээн дээр тулгуурлан мэдлэгийн трансформаци (уламжлалыг өсгөн дамжуулах)-ын зүй тогтлыг илэрхийлэх арга зүйн зарчмуудыг баримтлан уламжлал шинэчлэлийн асуудалд улирал дэвших диалектик зүйн тогтнолын үүднээс хандахдаа В.Ф.Гегель (1837), Н.И.Конрид (1966), Л.Н.Гумилев (1989), Н.Хавх (1995) нарын үзэл баримтлалын ерөнхий чиг зарчмыг тус тус баримталж ажигласан болно. Эх бичгийн судалгааг эх бичиг судлалын өнөөгийн төвшинд аль болох ойртуулахыг чармайн Монгол эрдэмтэн лам нараас Лувсанданзанжанцан (1639-1704), Ишбалжир (1704-1788), Жамбал (1789-1838), Жамбалдорж (1792-1855), Лувсанчойнпил (XIX зуун), Жигмэдданзанжамц (XIX зуун) нарын зохиосон судалгаанд авсан номуудын уг эх, нэр, гол онцлог, агуулга, галиг, тайлбар зэргийг нэгэн дор хамтатган судлав[3].

Үр дүн: Бид судалгаандаа эхлээд XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн Монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний 40 номыг олж цуглуулан ашиглав. Эдгээр тус бүрээс гоо сайхантай холбоотой, арьсны янз бүрийн өвчнийг эмчлэх эмийн ургамал тэдгээрийн нийлмэл найрлагыг тогтоосон. Гэвч зарим эртний номуудад гоо сайханд хэрэглэдэг ургамал, эмийн найрлага байхгүй байв. Гоо сайханд хэрэглэдэг ургамал, эмийн найрлагатай номуудыг түүвэрлэхэд нийт 7 ном байлаа. Эдгээр номуудын зохиогчийн төрсөн оноор нь дарааллуулан товч тодорхойлон, улмаар гоо сайханд хэрэглэдэг ургамлын латин нэрийг тогтоож, найрлагуудын нэр, номын нэр, зохиогчийн нэрийг төвөд хэлний Wylie transliteration-аар бичлээ.

Монгол эрдэмтэн лам нараас Лувсанданзанжанцан (1639-1704), Ишбалжир (1704-1788), Жамбал (1789-1838), Жамбалдорж (1792-1855), Лувсанчойнпил (XIX зуун), Жигмэдданзанжамц (XIX зуун) нарын бичсэн номонд арьсны өвчний ангилал, эмчилгээг хамгийн тод томруун гаргажээ. (Зураг 1)



Зураг 1. Судалгаанд ашигласан Монгол зохиогчтой анагаах ухааны эртний номын жишээ зургууд. (Хувийн номын санд хадгалагдаж байна)

1. Лувсанданзанжанцан (1639-1704): Ламын гэгээний анхдугаар дүр Лувсанданзанжанцан нь 1639 оны хаврын тэргүүн сарын шинийн 15-нд Сайн ноён хан аймгийн Өлзийт овоо (одоогийн Өвөрхангай аймгийн Хангай ханы орчим) гэдэг газар мэндэлжээ. Тэрээр анагаах ухааны чиглэлээр 5 ном бичсэн байна. Үүнээс “Увдисын рашааны цацрал оршвой” (mkhan chen chos kyi rgyal po’i gsung ‘bum las man ngag bdud rtsi zegs ma bzhugs so) хэмээх 18 хуудастай номондоо хүний толгой, нүд, чих, ам, хамар, хоолой, арьсны өвчнүүдэд үзүүлэх эмчилгээний тусламж, хүүхэд эмэгтэйчүүдэд зонхилон тохиолддог зарим өвчнүүдийг эмчлэх өөрийн туршлага, сургамжаа дүгнэн бичжээ[4]. Ерөнхийдөө энэ бол “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-ийн товч тайлбар зохиол болно. Лувсанданзанжанцан “Увдисын рашааны цацрал” зохиолын “Арьсны өвчин” бүлэгт нүүрний гоо сайхантай холбоотой дараах баримт байна. Үүнд: Шумхан (Pyrola incarnate), гаа (Zingibar officinalie Willd Rosc), шар гаа (Curcuma longa) гурвын найруулан сэвх, гүвдрүү тэргүүтнийг арилгана гэж бичжээ. Энэ зохиолд арьсны өвчний шалтгаан, нөхцөлийг бичээгүй харин эмчлэх аргыг ерөнхийд нь шүлэглэж товч бичсэн байна [5].

2. Ишбалжир (1704-1788): Сүмбэ хамбын өөрийнх нь бичсэн намтарыг үндэслэвэл тэрбээр Хөхнуур мужийн Хатан голын хөвөөн дэх Толь гацааны хүн юм. 1704 оны намар, билгийн улирлын 8 сарын 15-ны өглөө Монголын Ойрад аймгийн Баатуд овгийн тайж Дорждашийн 4 дүгээр хүү болон төржээ. Ишбалжир залуу наснаасаа орон нутагтаа болон бусад газар оронд очиж анагаах ухаанд суралцаж, анагаах ухааны мэдлэгийг эзэмшсэн байна. Ялангуяа Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны сонгодог зохиолд нэвтэрсэн мэдлэг, дадлагын явцдаа Монголчуудад зонхилон тохиолддог өвчнийг анагаах ихээхэн туршлагыг хуримтлуулж, анагаах ухааны том, жижиг 7 зохиол бичсэн[6]. Эдгээрээс хамгийн алдартай нь “Дөрвөн рашаан”, “Цагаан болор толь” гэдэг номууд бий. Энэ номонд нүүрний сэвх, нүүрэн дээр гарсан яр батгыг эмчлэх хэд хэдэн найрлагыг бичжээ. Арьсны өвчин, нүүрний сэвхэнд энгэсэг (Butea monosperma)-ийг гуулин данханд буцалган шүүсээр нь нүүрээ угаана гэсэн бол мөн вала (Yellow orpiment), донрой (Realgar mineral medicine) хоёрын аль нэгийг бойгар (Liquidambar formosana Hance), олмосэ (Podophyllum emodi wall)-гийн үндэстэй найруулан сүү хадгалдаг саванд наалдсан тостой хольж түрхэн наранд ээвэл эдгэнэ. Мөн дээрх эмүүдийг үнээний шээсэнд найруулан түрхсэнээр сэвхийг эмчилнэ гэж тус тус бичсэн байна.

Ишбалжирын “Цагаан болор толь” номонд цээнэ (Paeonia anomala L)-ийг арьсны цэцэг гэж нэрлэдэг. Арьсны өвчин, нүүрэнд гарсан элдэв сэвх, батгыг эмчилнэ. Үхрийн сүүнээс гарган авсан тарагны хуучин ээдэм арьсны өвчнийг арилгаж чацага алдахыг зогсооно. Сүү хадгалдаг саванд тогтсон өнгөр нь шар ус, арьсны өвчин, бадган, хийг эмчлэхэд тустай. Цагаан морины туурайн үнс бол мэнгэ зэрэг арьсны өвчнийг арилгана гэсэн байна[7].

3. Жамбал (1789-1838): Жамбал 1789 онд Дээд Монголын Хөх нуурын Улаан мөрний хөвөөнд орших Толь гацаанд малчин Дондовцэдэнгийн гэрт төржээ. Түүний бичсэн номнуудаас 1830-1832 онд «Замбутивийн дэлгэр номлол» хэмээх хамтын бүтээл нь их алдартай ба англи, орос, франц зэрэг хэлээр орчуулагдсан байна. “Увдисын далай” (gso rig bstan bcos mtha› dag gi snying po rnams phyogs gcig tu bsdus pa man ngag rin chen ‹byung gnas bzhugs so) хэмээх эм найрлагын номыг 1829 онд төвөд хэлээр зохион модон бараар хэвлүүлжээ. Уг номонд үндсэн өвчин, халуун өвчин, нян өвчин, таван эрхтний өвчин, цул савын өвчин, аахар шаахар өвчин, гадар яр зэрэг өвчнийг засах аргыг 112 бүлэгт хуваан үзүүлж, нийт 2528 эм найрлага хураангуйлагдан эмхэтгэгджээ[8]. Энэ номонд арц (Juniperus sabina L), улаан зандан (Pterocarpus santalinus)-г нунтаглан тосыг нь ялган авна. Ялган авсан тосыг арьс, нүүрэнд түрхвэл загатнах, нясуу, сэвх

зэрэг өвчнийг эмчилнэ. Нарс мод (Pinus sibirica), хүн, гахай, морины яс зэргийг дээрх мэтээр тосыг нь гарган авч нүүрний сэвхэнд түрхвэл эдгэнэ гэж тэмдэглэжээ[9].

4. Жамбалдорж (1792-1855)**:** Найман тойн Жамбалдорж XIII жарны усан хулгана жил, 1792 онд Найман хошууны есдүгээр засаг төрийн дархан ван, Чингис хааны угсаа болох эцэг Балчиг хийгээд эх Балмо хоёрын хоёрдугаар хөвгүүн болж төрсөн бөгөөд эцэг, эх нь түүнд Жамбалдорж гэдэг нэр хайрлажээ. Долоон наснаасаа эхлэн Монгол, Төвөд, Манж, Хятад бичгийг сурч, Түмэд гүүш Лувсанчойпил, Харчин тойн Түдэвням, гүнтан Гончигдамбийдонмэ, лам Ванчигчойсан, Лувсанданзан ринбүүчий тэргүүтэн 150 гаруй Монгол, Төвөд эрдэмтэн багш нарыг оройн чимэг болгон шүтэж "Ганжуур", "Данжуур" мэтийн гурван зуу гаруй боть зохиолын иш лүнг хүртэж гол болох зуун хөтөлбөр, зуун авшиг, зуун жинан даган соёрхлыг хүртэн сонсч байжээ. Тэрбээр "Үзэсгэлэнт нүдэн чимэг", төвөдөөр "Зэйцар мигжан" болон "Хиргүй болор эрхт өгүүлсэн эмийн түнбэ гайхамшигт үзэсгэлэнт нүдний чимэг" (товчоор Бага үзэсгэлэнт нүдэн чимэг) гэдэг хоёр зохиолыг 1817-1823, (1911) оны хооронд бичсэн бөгөөд гадаад, дотоодын эрдэмтэд өнгөрсөн зууны дунд үеэс судласаар өнөөг хүрчээ[11].

"Үзэсгэлэнт нүдэн чимэг" номонд нарс модны давирхай (Pinus cembra Sibirica) нь шаравтар тунгалаг өнгөтэй байдаг. Хаванг арилгаж, шар усыг арилгах тул нүүрэнд гарсан яр шархыг хатаана. Емон (Atragene Sibirica L) нь ялзарсан махыг таслан, шар усыг татна. Сибирийн гүйлс (Armeniaca Sibirica) гэдэг. Толгойн үсийг ургуулж, нүүрний шархны шар усыг хатаана. Бридасазин (Polygonum aviculare) буюу монголоор Малгайн залаа өвс гэнэ. Арьс, нүүрний өгөр цус, шар усыг татна гэжээ[12].

5. Лувсанчойнпил (XIX зуун): Тэрээр XIX зууны үед амьдарч байсан ба Цэцэн хан аймгийн Эрдэнэ Далай вангийн хошуу (одоогийн Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт)-д төрсөн боржгон овогтой тойн хүн юм. Эцэг нь тайж хүн байсан бөгөөд хүүгээ лам болгож бурхны шашны мөр хөөлгөхөөр зорьсон тул тойн болжээ. Тойн гэдэг нь язгууртан, тайж угсаатай хүний хүү лам болоход өгдөг нэр ажээ. Лувсанчойнпил хэд хэдэн судар ном зохиосон гэдэг мэдээ байдаг. Эдгээр бүтээлийн дотор анагаах ухааны чиглэлээр туурвисан 234 хуудастай, "Нандин эрдэнийн шимийн хураангуй" (sman gzhung khungs ma rnams las nad kyi rtags bcos sogs thor bur 'byung ba phyogs gcig tu bsgrigs pa gces btus snying nor) гэдэг эмчилгээний чухал ном бий[13]. Энэ номны арьсны өвчний бүлэгт сэвх, цахлайд цагаан өнгөтэй морины туурайг шатааж, үнсийг нь тостой найруулж түрхэнэ. Эсвэл шумхан (Pyrola incarnate), бурам (Molasses), бойгар (Liquidambar formosana Hance), бүшэлз буюу шар цахилдаг (Belamcanda chinensis), зөгийн бал (Honey), тосыг үнээний шээстэй найруулан буцалгаж түрхвэл мэнгэ, сэвхийг арилгана гэж тэмдэглэсэн байна.

6.Жигмэдданзанжамц(XIXзуун):Жигмэдданзанжамц нь Өвөр Монголын Шилийн голын чуулганы зүүн Сөнөд хошуунд (Одоогийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн зүүн Сөнөд хошуу) төрсөн. XIX зууны сүүлч XX зууны эхээр амьдарч байсан хүн ажээ. Тэрбээр "Үзэгсдийн баясгалан" (rgya bod mkhas grub du ma'i gzhung lugs dam pa gong ma rnams kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal dga' byed snying po'i rnam gsal bzhugs so) номоо 1888 онд бичсэн. Бурам (Molasses), бал (Honey), тосыг үнээний шээсэнд найруулан нүүрэнд түрхвэл мэнгэ, сэвхийг арилгана. Мөн сэвх, цахлай, үлдийг цагаан морины туурайн үнсийг тостой найруулж түрхвэл эдгэнэ. Шар гаа (Curcuma longa), шар мод (Sympegma Regelii), руда (Aucklandia lappa Decne), тэмээн хөх (Momordica cochinchinesis lour), нишинг (Asparagus Dahuricus) найруулж эмчилнэ гэж тус тус тэмдэглэсэн байна.[14]

Хэлцэмж: Монголын уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ, заслын хөгжил 1937-1990 он хүртэл тасарсан. Харин 1990 оноос уламжлалт анагаах ухаан сэргээгдэн хөгжиж эхэлсэн. Манай судлаачдын сүүлийн 30 шахам жилд хийсэн эрдэм судлалын ажлын үр дүнд Монголын уламжлалт анагаах ухаан 5000 гаруй жилийн түүхтэй бөгөөд энэхүү анагаах ухаан өвөг Монголчууд, Монголчуудын оюун ухаан, эрдэм мэдлэгийн үнэт өвүүдийн нэг гэдгийг тогтоосон[15]. Монголын уламжлалт анагаах ухааны өнгөрсөн зууны ололт, туршлага, сургамж нь XXI зуунд тус улсын эрүүл мэндийн салбарын зарим чиглэлийг шинэчлэн хөгжүүлэх, хүн амынхаа эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Эдгээр чиглэлийн нэг нь гоо сайхны шинжлэх ухаан юм.

Бид энэ удаа судлаачдын хамгийн эрж хайдаг, өнөө цагт нэн ховордсон уламжлалт анагаах ухааны эртний эм, эмчилгээний 40 номыг сүүлийн 30 шахам жилд эрж сурвалжлан олж тогтоосон. Эдгээр номуудаас 7 номонд нь гоо сайхны шинжлэх ухаан түүн дотроо арьсны өвчин, нүүрний арьсны зарим өвчин, гоо сайхныг алдагдуулдаг үрэвсэлт болон үрэвсэлт бус өвчний эмчилгээнд хэрэглэдэг амьтны гаралтай 7, ургамлын гаралтай 17 эмийн түүхий эд байгааг тогтоолоо. Тогтоосон эмүүдийг монгол нэрээр нь хөөн судалж латин нэрийг нь мөн тогтоосны зэрэгцээ, хэрхэн, яаж анагаах ухааны практикт хэрэглэж ирснийг тодруулан гаргасан.

Амьтны гаралтай 7 эмийн түүхий эд болох цагаан морины туурай, үхрийн сүү, хүний яс, гахайн яс, морины яс, үнээний шээс, зөгийн балнаас хүний яс л орчин цагийн анагаах ухаанд хэрэглэдэггүй. Бусад нь хэрэглэгдэж байна. Гэхдээ нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд хүний ясыг 19 дүгээр зууны сүүл хүртэл эмийн найрлагад хэрэглэж байгаад түүнээс хойш хэрэглэхээ больсон. Хэрэглэж байсан эрт цагт өвчтэй хүний ясыг бус ямар нэгэн шалтгаанаар цаазлуулсан залуу хүний ясыг авч хорыг нь гарган хэрэглэдэг байжээ. Үүний зэрэгцээ арьс, гоо сайханд хэрэглэдэг дараах эмийн ургамлуудыг олж тогтоосон. Үүнд:

1. Арц (Juniperus sabina L)
2. Улаан зандан (Pterocarpus santalinus)
3. Нарс мод (Pinus sibirica)

4. Нарс модны давирхай (Pinus cembra Sibirica)
5. Емон (Atragene Sibirica L)
6. Сибирийн гүйлс (Armeniaca Sibirica)
7. Малгайн залаа өвс (Polygonum aviculare)
8. Шумхан (Pyrola incarnate)
9. Бурам (Molasses)
10. Бойгар (Liquidambar formosana Hance)
11. Шар цахилдаг (Belamcanda chinensis)
12. Бурам (Molasses)
13. Шар гаа (Curcuma longa)
14. Шар мод (Phellodendron amurense Rupr)
15. Руда (Aucklandia lappa Decne)
16. Тэмээн хөх (Momordica cochinchinesis lour)
17. Нишин (Asparagus Dahuricus)

Монголын уламжлалт анагаах ухааны эртний эмч нар эмийнхээ чанар, чадлыг сайжруулах зорилгоор эмт бодисыг хэрхэн зөв таних түүний эмчилгээний үйлдлийг тал бүрээс нь нээн илрүүлэх талаар онцгой анхаарч иржээ. Үүний тод жишээ нь энэ удаагийн судалгаанд ашигласан монгол эрдэмтэн лам Ишбалжирийн (1704-1788) зохиол “Цагаан болор толь”, Жамбалдоржийн (1792-1855), “Үзэсгэлэнт нүдэн чимэг”, “Эмийн түнбэ үзэсгэлэнт нүдэн чимэг” номууд юм. Ишбалжирийн “Цагаан болор толь” номонд нийтдээ 968 зүйлийн эмийн түүхий эд, идээ ундааны хэрэглээг маш товч тэмдэглэсэн байна [16]. Харин Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг”, “Эмийн түнбэ үзэсгэлэнт нүдэн чимэг” гэсэн номуудад тус бүртээ 800 гаруй амьтан, ургамал, эрдсийн гаралтай эмийн түүхий эдийг багтаажээ[17]. Эдгээр эмийн түүхий эдээс гоо сайханд хэрэглэж байсан эмийн түүхий эдийг түүвэрлэн авсан. Лувсанданзанжанцангийн зохиосон (1639-1704) “Увдисын рашааны цацрал”, Лувсанчойнпилын (XIX зуун) “Нандин эрдэнийн шимийн хураангуй”, Жигмэдданзанжамцын (XIX зуун) “Үзэгсдийн баясгалан” нарын бичсэн номонд арьсны өвчний ангилал, эмчилгээг ялангуяа гоо сайханд хэрэглэдэг эм, эмийн найрлагыг бичсэн. Харин Жамбалын (1789-1838) “Увдисын далай” номонд 2528 зүйлийн эм, эм найрлагын хэрэглээг маш сонирхолтой тайлбарлан тодорхойлсон[18]. Ялангуяа зарим эм, эм найрлагын чанарын сайн муу ялгааг хэрхэн таних нарийн арга ухааныг зааж өгсөн нь Монголын уламжлалт анагаах ухаанд оруулсан их хувь нэмэр болсон.

Цаашид гоо сайханд хэрэглэдэг эмчилгээний аргуудыг судалгаанд ороогүй анагаах ухааны эртний бусад номуудаас олж тогтоох нь чухал байна. Түүнээс гадна одоо олж тогтоосон эмийн ургамлуудын химийн найрлагыг тогтоох, эм судлалын судалгааг хийх шаардлагатай байна. Ингэснээрээ уламжлалт анагаах ухааны гоо сайхны салбарыг хөгжүүлэх практик хэрэглээг нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг сургалтанд хэрэглэх боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Мөн гоо сайхны салбар өндөр хөгжсөн орнуудын гол шаардлага болсон эмийн түүхий эдийг зөв танихаас эхлээд зохих үед нь зөв хураах цэвэрлэх, боловсруулах, номхотгох, хадгалах уламжлалт эмийн аюулгүй байдал, чанарыг хангах нь чухал юм.

Дүгнэлт: XVII зууны сүүлчээс XX зууны эхэн хүртэлх үеийн монгол эмч, эрдэмтдийн бичсэн анагаах ухааны эртний 7 судраас гоо сайханд хэрэглэдэг идээ ундаа, амьтан ургамлын гаралтай эмийн түүхий эдийн түүвэр хийж тайлбарлав. Сүүлийн 10 гаруй жилд Монгол Улсад гоо сайхны шинжлэх ухаан эрчимтэй хөгжих суурь тавигдсан. Үүнийг дагаад ургамлын гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол түүхий эд болох эмийн ургамлыг олж тогтоох, судалгаа хийх шаардлага тавигдаж байна. Үүний гол нөөц, нотолгоонд суурилсан уламжлалт мэдлэгийг нээн гаргах гол боломжийн нэг нь анагаах ухааны эртний номуудыг судлах асуудал юм.

Ном зүй:

1. *Болд Ш. Төвөд хэл сурах бичиг (bod skad bslab deb). Улаанбаатар, 2011, х.7-8*
2. *Цэцэгдарь Т. XIX-XX зууны эхэн хүртэлх Монголын зарим мамба дацангийн зохион байгуулалт сургалтын онцлогийг тодруулах нь. Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. ЭЗШУИС, УБ, 2017, х.44*
3. *Sharav Bold. The development of traditional Mongolian medicine was clarified by the source materials. Abstract of Dissertation for Doctor of Science degree in Medicine. Ulaanbaatar, 2005, p.8*
4. *Б.Сумьяацэрэн. Хамба номун ханы “Увдист рашааны дусал” сударт буй илт өгүүлэх нэр, зарим эмийн тайлбар. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2021, х.13-14*
5. *Лувсанданзанжанцан. “Увдисын рашааны цацрал”. Модон барын төвөд судар.*
6. *Б.Оюун-Эрдэнэ. Сүмбэ хамба Ишбалжирын намтар, бүтээлийн судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2015, х.27*
7. *Ишбалжир “Дөрвөн рашаан”, “Цагаан болор эрхи”. Модон барын төвөд судар.*
8. *Жамбалчойжиданзанпэрэнлэй. Увдисын далай. (орчуулсан Ш.Болд, Х.Улаан-Од, Д.Шагдарсүрэн). Боть 19. УБ, 2023, х.7-8*
9. *Жамбалчойжиданзанпэрэнлэй. Увдисын далай. (орчуулсан Ш.Болд, Х.Улаан-Од, Д.Шагдарсүрэн). Боть 19. УБ, 2023, х.209*
10. *Bold Sharav. Collection of Ancient Books on Mongolian Medicine Written and Translated in Mongolian, Chinese, Tibetan, Manchu, Russian, and Model of Medicinal Artworks of Beautiful Eye Ornament. Ulaanbaatar, 2024, p.24-25*
11. *Эрдэнэбаяр. “Найман тойн Жамбалдоржийн намтар” судлал. ӨМ-ын Ардын хэвлэлийн хороо. 2009, х.26-27*
12. *Жамбалдорж. “Үзэсгэлэнт нүдэн чимэг” (Mdzes mtshar mig rgyan). Модон барын төвөд судар.*
13. *Лувсанчойнпил. Sman gzhung khungs ma rnams las nad kyi rtags bcos sogs thor bur 'byung ba phyogs gcig tu bsgrigs pa gces btus snying nor. Модон барын төвөд судар.*
14. *Лувсанчойнпил. Sman gzhung khungs ma rnams las nad kyi rtags bcos sogs thor bur 'byung ba phyogs gcig tu bsgrigs pa gces btus snying nor. Модон барын төвөд судар*
15. *Жигмэдданзанжамц. Rgya bod mkhas grub du ma'i gzhung lugs dam pa gong ma rnams kyi man ngag zhal shes lag len myong grub gnad don gnyen po ngo sprod mdzub tshugs dmar khrid kyi bkod pa mthong ba don gsal dga'byed snying po'i rnam gsal bzhugs so. Модон барын төвөд судар.*
16. *Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Тэргүүн боть, УБ, 2014, х.12*
17. *Ишбалжир. “Цагаан болор эрхи”. Модон барын төвөд судар.*
18. *Жамбалдорж. “Үзэсгэлэнт нүдэн чимэг” (Mdzes mtshar mig rgyan). Модон барын төвөд судар.*
19. *Жамбалчойжиданзанпэрэнлэй. Увдисын далай. (Орчуулсан Ш.Болд, Х.Улаан-Од, Д.Шагдарсүрэн). Боть 19. УБ, 2023*

Clarify some medicinal raw materials used in beauty from ancient medical books written by mongolian scholars

Hugejiletu[1], Dorjbat S[1], Enkhtur Ya[2], Bold Sh[3,4]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS
[2]School of Medicine, MNUMS
[3]"Ach" Medical University
[4]Mongolian University of Pharmaceutical Sciences
E-mail: boldshrv@gmail.com, Tel:+976-80687670

Background: In the last ten years, Mongolia has established the foundations for the intensive development of cosmetic science. At the same time, research on medicinal plants, the main crude drugs for producing herbal cosmetic products, is being conducted on a large scale. Almost 900 species of medicinal plants grow in Mongolia. However, it is important to determine which plants are used for beauty.
Aim: To address the issue, we identified medicinal plants used in beauty from ancient medical scriptures written by Mongolian lama medical practitioners and scientists from the end of the XVII century to the beginning of the XX century.
Materials and Methods: The research used 40 ancient medical books of Mongolian lama medical practitioners from the end of the XVII century to the start of the XX century. In particular, the classification and treatment of skin diseases were most clearly presented in the books written by Luvsandanzanjantsan (1639-1704), Ishbaljir (1704-1788),
Results: Jambal (1789-1838), Jambaldorj (1792-1855), Luvsanchoinpil (XIX century) and Jigmeddanzanjamts (XIX century). Medicinal plants and ingredients for treating facial skin diseases were determined from each book collected. However, some ancient books did not contain relevant herbal or medicinal ingredients. Seven books on herbs and medicinal ingredients used in beauty were selected. The authors of these books are briefly identified one by one with their birth dates, and then the Latin and English names of the plants used in beauty are determined. The names of the books are written in Wylie, a transliteration of Tibetan. We selected 17 medicinal plants and 7 animal-oriented medicines used in beauty and explained them from 7 ancient medical books written by Mongolian lama medical practitioners.
Conclusion: From the 7 ancient medical sutras written by Mongolian doctors and scientists from the end of the 17th century to the beginning of the 20th century, a selection of food and drink and medicinal raw materials of animal and plant origin used in beauty is explained. In the last 10 years, the foundation for rapid development of beauty science has been laid in Mongolia. Along with this, there is a need to identify and research medicinal plants, which are the main raw materials for the production of herbal cosmetics. One of the main resources and opportunities for discovering evidence-based traditional knowledge is the study of ancient medical books.

Keywords: Cosmetic science, Medicinal plants, Beauty, Aancient medical books, Mongolian lama